



НИЙСЛЭЛИЙН
ТӨР ЗАХИРГААНЫ АВТО БААЗ УТҮГ
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 04 сарын 24 өдөр

Дугаар А/35

Улаанбаатар хот

Техникийн байнгын комисс болон журмыг
шинэчлэн батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.1.10, Авто тээврийн тухай хуулийн 6.1.4 дэх заалт, Зам тээвэр барилга хот байгуулалтын сайдын 2011 оны 153 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын автомашин хөдлөх бүрэлдэхүүн, автомашины сэлбэг хэрэгсэл, бензин, шатах тослох материалын зарцуулалтад хяналт тавьж, тооцож ажиллах зорилгоор Техникийн байнгын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн томилсугай.

Комиссын дарга
Гишүүд

Х.Ажрахгүй /Ерөнхий инженер/
О.Халиун /Хүний нөөцийн ахлах менежер/
Б.Үүрцайх /Ерөнхий нягтлан бодогч/
Н.Дуламсүрэн /Тооцооны нярав/
М.Сүхбат /Ашиглалтын инженер/

Нарийн бичиг

2. Техникийн байнгын комиссын ажиллах журмыг нэг дүгээр хавсралтаар, комиссын дүгнэлтийн маягтыг хоёр дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

3. Тушаал гарсантай холбогдуулан Нийслэлийн Төр захиргааны авто баазын даргын 2012 оны А/85, 2019 оны А/60 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ш.НАРАНБААТАР

Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын даргын 2020 оны 24 дүгээр сарын 24-ны өдрийн 1/35 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



НИЙСЛЭЛИЙН ТӨР ЗАХИРГААНЫ АВТО БААЗЫН ТЕХНИКИЙН БАЙНГЫН КОМИССЫН АЖИЛЛАХ ЖУРАМ

Авто баазын даргын 201.. оны .. дугаар сарын ..-ны өдрийн ... дугаар тушаалаар томилогдсон Техникийн байнгын комисс нь авто баазын техникийн асуудлыг шууд хариуцан дараах журмаар ажиллана.

1. Байгууллагын автомашин, хөдлөх бүрэлдхүүн, автомашины запас сэлбэг хэрэгсэл, бензин, шатах тослох материалын зарцуулалтанд хяналт тавьж, шаардлагатай сэлбэг хэрэгслээр хангах ба шалгах механикийн гаргасан үзүүлэлт болон засварын инженерийн үзлэгийн дагуу Техникийн байнгын комиссын дүгнэлтийг бүрэн бичиж, баталгаажуулан, шинээр сэлбэг хэрэгслийг сольж тавих болон хуучин сэлбэг хэрэгслийг хураан авч, няравт тушаахдаа дараах байдлаар ажиллана.

2. Автомашинд шинээр сэлбэг тавих зөвшөөрлийг Техникийн байнгын комиссын дүгнэлт, диспетчер механикийн шалгасан үзүүлэлтийг үндэслэн, Ерөнхий инженер олгоно.

3. Авто баазын Техникийн байнгын комиссын дүгнэлт, зөвшөөрлийн дагуу зөвхөн инженер, нярав нар сэлбэгийг худалдан авч өгнө.

4. Жолооч нар зөвшөөрөгдсөн шинэ сэлбэгийг нярваас авч авто баазын засварын өрөөнд байгууллагын засварчнаар болон бусад засварын газарт мэргэжлийн засварчнаар тавиулна .

5. Худалдаж авсан болон шилжиж ирсэн /захирамж, тушаал, шийдвэрээр/ автомашинуудыг комисс хүлээлцэж, тусгай маягт-“Автомашин хүлээлцэх акт”-аар болон фото зургаар баталгаажуулан жолооч нарт хүлээлгэн өгч, “Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ”-г жолоочтой хийнэ. Техникийн байнгын комиссын бүрэлдхүүн гарын үсэг зурж баталгаажуулан автомашинуудад хувийн хэрэг хөтлөн ажиллана.

6. Автомашин аваар осолд орж эвдэрсэн үед эрх бүхий байгууллагуудын дүгнэлтийг үндэслэн (Замын цагдаа, даатгал, үнэлгээний байгууллага) автомашины эвдрэлийг тодорхойлуулж, байгууллагын Техникийн байнгын комиссын дүгнэлт гарган байгууллага, хувь хүмүүсийн хохирлыг барагдуулан ажиллана.

7. Техникийн байнгын комисс нь нийслэлийн харьяа газруудын болон хүсэлт гаргасан аж ахуйн нэгж байгууллагуудын автомашинд тодорхой үнэлгээний дагуу /нэг автомашин 50000 төгрөг/ Техникийн комиссын дүгнэлтийг гаргаж өгнө.

8. Авто баазын тээврийн хэрэгсэл, автомашинуудын шатахуун зарцуулалтын жишиг нормийг эрх бүхий дээд байгууллагаас гаргасан тогтоол, шийдвэрийн дагуу батлан мөрдөж, өөрчлөлт орсон тухайн үед Техникийн байнгын комиссын хурлаар өөрчлөлт хийж ажиллана.

9. Автомашины сэлбэгүүдийн эдэлгээний нормийг гаргахдаа Монгол Улсын Дэд бүтцийн сайдын тушаалаар батлагдсан “Авто тээврийн хэрэгслийн ашиглалтын норм”-ийг баримтлан тогтооно.

ТЕХНИКИЙН БАЙНГЫН КОМИСС